



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 6/27

Зуунмод

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ЭД ХӨРӨНГИЙН ТООЛЛОГО
ЯВУУЛАХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72 дугаар зүйл, Сангийн сайдын 2016 оны 126 дугаар тушаал, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 439 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. 2016 оны жилийн эцсийн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Болормаа / Барилга угсралт, технологи, техникийн хяналт хариуцсан мэргэжилтэн /


Гишүүд:Д.Цогтсайхан /Инженерийн барилга, байгууламж хариуцсан мэргэжилтэн/

Ц.Бямбасүрэн /Мэдээллийн сан, программ, техник хангамж хариуцсан мэргэжилтэн/

Хоёр. Тооллогыг 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор хийж дуусган дүнг Газрын даргын зөвлөлд танилцуулахыг комиссын дарга /Б.Болормаа/-д үүрэг болгосугай.

Гурав. Тооллогын бэлтгэл ажлыг хангаж хөрөнгийн дахин үнэлгээ болон актлах хөрөнгийн талаар санал боловсруулж танилцуулах, тооллогын ажилд хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч /Д.Бадамханд/-д даалгасугай.

ДАРГА



АЛХАГВАХОРОЛ